

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Таван толгой түлш ХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2024/7/НА-СТА-ТӨА

Цахим хуудас: www.audit.mn	Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Улаанбаатар хот	Утас: 51-261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
2024 он	Аудитын менежер: С.Нацагдорж Утас: 51-261885 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn
	Ахлах аудитор: Ж.Энхтуяа Утас: 51-261740 Цахим хаяг: enkhtuyaj@audit.gov.mn
	Нийслэл-Аудит ХХК-ийн захирал: Т.Сугарсүрэн Утас: 70110095 Цахим хаяг: info@niislelaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ТАВАН ТОЛГОЙ ТҮЛШ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ц.ДАВААЦЭРЭН
ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.03.25 № 07/842
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Таван толгой түлш ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Таван толгой түлш ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 68,789.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс давж, дангаараа буюу эсвэл нийтээрээ материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Тухайлбал:

- Нүүрс баяжуулах үйлдвэр болон хагас коксын үйлдвэрийн бүтээн байгуулалттай холбоотой сонгон шалгаруулалтгүй шууд гэрээ байгуулан ажил эхлээгүй байхад нийт 14,544.3 сая төгрөгийн урьдчилгаа олгосон боловч гэрээт ажил бүрэн хийгдээгүй;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг зөрчиж 1,397.3 сая төгрөгийн бараа, ажил үйлчилгээний худалдан авалт хийсэн;
- Ажилласан цагийг ERP системээр тооцсон бодит ажлын цагтай уялдуулаагүйгээс илүү цагийн хөлсийг 36 ажилтанд 274.3 сая төгрөгөөр илүү, 12 ажилтанд 10.0 сая төгрөгөөр дутуу олгосон;
- Нүүрс баяжуулах үйлдвэрийн төсөлд тайлант оны байдлаар 49,836.9 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн 11 гэрээт ажил нь 60.0-100.0 хувийн гүйцэтгэлтэй боловч ажлыг бүрэн хүлээж авч, хөрөнгийн бүртгэлд тусгаагүй, цаашид төслийг

үргэлжлүүлэх эсэх талаар төлөөлөн удирдах зөвлөл, хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр гараагүй, төслийн ажлыг зогсоосон зэрэг зөрчил илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, 8.5, 34 дүгээр зүйлийн 34.1, 34.3 дахь заалтуудтай нийцэхгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Таван толгой түлш ХХК нь шахмал түлш үйлдвэрлэлийн үйл ажиллагааг сайжруулах ач холбогдол бүхий бодлогын чанартай дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

- Сайжруулсан шахмал түлшний төвийн болон зүүн үйлдвэрийн хүчин чадал, бүтээмжийг 2.5-3 дахин нэмэгдүүлснээр үйлдвэрлэлийн зардлыг жилд 10 хувиар хэмнэх нөхцөл бүрдсэн;
- Нийтдээ 625 у/м төмөр замыг барьж ашиглалтад оруулснаар түлшийг 100.0 хувь галт тэргээр тээвэрлэж тээврийн зардлыг 30.0 хувь бууруулах нөхцөл бүрдсэн;
- Химийн шинжилгээ, туршилтын лаборатори, тоног төхөөрөмжийн засварын газрыг шинээр барьж байгуулснаар бүтэгдэхүүний түүхий эд болон бэлэн бүтэгдэхүүний чанар үйлдвэрлэлийн үр ашиг нэмэгдэх боломжтой болсон;
- Компанийн 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн гүйцэтгэлийг тодотгосон төлөвлөгөөтэй харьцуулж үзэхэд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өртөг 6.8 хувиар өссөн нь төмөр замын компаниуд мидлинг тээвэрлэлтэд тарифын хөнгөлөлт үзүүлэхээ больсонтой холбоотой байна. Компанийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өртөг өссөн ч удирдлагын зардлыг төлөвлөснөөс 18,157.7 сая төгрөгөөр, борлуулалтын зардлыг 1,131.5 сая төгрөгөөр нийт алдагдлын хэмжээг 14,042.4 сая төгрөгөөр тус тус бууруулсан байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд нийт борлуулалтын орлогыг 76,635.3 сая төгрөгөөр, Эрдэнэс таван толгой ХК-аас авах санхүүжилтийн орлогыг 339,931.0 сая төгрөгөөр, нийт зардлыг 401,686.4 сая төгрөгөөр, үйл ажиллагааны үр дүнг 233,108.9 сая төгрөгийн алдагдалтайгаар баталсан ба хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 84,452.9 сая төгрөг төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 518.8 мян.тн шахмал түлшийг 77,817.9 сая төгрөгөөр борлуулж, үйл ажиллагааны бус орлогоос 713.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, нийт 300,709.4 сая төгрөгийг үйлдвэрлэл, үйл ажиллагааны зардалд зарцуулж 219,066.4 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Таван толгой түлш ХХК нь 2023 онд үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайлангаар 35 зорилтын хүрээнд 54 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн 84.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	14,814,234,847.44	24,177,426,624.94
1.1.2	Дансны авлага	-	865,171,960.39
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	357,696,141.02	4,510,080.00
1.1.4	Бусад авлага	999,447,649.16	71,957,645.00
1.1.6	Бараа материал	117,555,754,469.81	98,094,470,429.90
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	13,063,866,690.06	35,670,828,204.27
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	146,790,999,797.49	158,884,364,944.50
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	269,826,477,744.06	256,161,468,142.84
1.2.2	Биет бус хөрөнгө	502,172,509.31	4,519,684,610.75
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	270,328,650,253.37	260,681,152,753.59
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	417,119,650,050.86	419,565,517,698.09
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	50,305,163,423.10	20,935,811,943.23
2.1.1.2	Цалингийн өглөг	392,211,697.23	33,867,834.09
2.1.1.3	Татварын өр	1,392,385,375.49	1,038,503,784.30
2.1.1.4	НДШ-ийн өглөг	-	119,320,775.46
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	3,181,238,809.16	2,821,130,670.10
2.1.1.9	Нөөц / өр төлбөр /	7,097,385,017.35	787,772,890.73
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	-	169,599,520.28
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	62,368,384,322.33	25,906,007,418.19
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	801,865,892,199.69	1,067,296,527,463.41
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	801,865,892,199.69	1,067,296,527,463.41
2.2	Өр төлбөрийн нийт дүн	864,234,276,522.02	1,093,202,534,881.60
2.3	Эздийн өмч		
2.3.1	Төрийн өмч	1,000,000.00	1,000,000.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(447,115,626,471.16)	(673,638,017,183.51)
2.3.11	Эздийн өмчийн дүн	(447,114,626,471.16)	(673,637,017,183.51)
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	417,119,650,050.86	419,565,517,698.09

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	56,754,236,250.00	77,817,956,250.00
2	Борлуулалтын өртөг	175,458,300,964.35	247,310,825,594.58
3	Нийт ашиг (алдагдал)	(118,704,064,714.35)	(169,492,869,344.58)
5	Хүүгийн орлого	-	713,209,091.14
8	Бусад орлого	11,504,065,129.14	3,221,815,868.94
9	Борлуулалт, маркетингийн зардал	9,585,945,283.04	13,462,104,693.14
10	Ерөнхий ба удирдлагын зардал	68,034,432,655.76	37,925,497,836.95
11	Санхүүгийн зардал	380,823,905.78	0.00
12	Бусад зардал	5,468,042,269.77	982,401,967.57
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(1,736,880,928.37)	(38,721,564.37)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	0.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(192,406,124,627.93)	(217,966,570,446.53)
19	Орлогын татварын зардал	-	71,318,487.70
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(192,406,124,627.93)	(218,037,888,934.23)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(192,406,124,627.93)	(218,037,888,934.23)
24	Орлогын нийт дүн	(192,406,124,627.93)	(218,037,888,934.23)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,000,000.00	(254,209,288,135.27)	(254,208,288,135.27)
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	(500,213,707.96)	(500,213,707.96)
3	Залруулсан үлдэгдэл	1,000,000.00	(254,709,501,843.23)	(254,708,501,843.23)
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	(192,406,124,627.93)	(192,406,124,627.93)
5	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-
6	Өмчид гаргасан өөрчлөлт	-	-	-
7	Зарласан ногдол ашиг	-	-	-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-
9	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,000,000.00	(447,115,626,471.16)	(447,114,626,471.16)
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	(8,484,501,778.12)	(8,484,501,778.12)
11	Залруулсан үлдэгдэл	1,000,000.00	(455,600,128,249.28)	(455,599,128,249.28)
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	(218,037,888,934.23)	(218,037,888,934.23)
13	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,000,000.00	(673,638,017,183.51)	(673,637,017,183.51)

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	63,734,948,975.02	77,697,997,600.57
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	56,150,931,066.00	77,604,961,618.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	123,100,000.00	-
1.1.6	Бусад мөнгөн орлого	7,460,917,909.02	93,035,982.57
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	325,531,010,566.02	304,859,130,485.82
1.2.1	Ажиллагчдад төлсөн	62,265,870,608.17	73,481,732,300.03
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	29,692,001,821.80	21,993,949,440.05
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	188,729,344,437.89	110,756,098,259.50
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	6,699,164,393.29	9,998,492,072.91
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	8,495,579,391.49	40,290,523,922.36
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	8,198,508,076.07	15,223,025,602.54
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	154,840,000.00	-
1.2.9	Бусад мөнгөн зарлага	21,295,701,837.31	33,115,308,888.43
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(261,796,061,591.00)	(227,161,132,885.25)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	18,030,632,703.00	713,209,091.14
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	18,030,632,703.00	-
2.1.6	Хүлээн авсан хүүгийн орлого	-	713,209,091.14
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	55,962,155,360.01	29,567,879,448.63
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	12,407,297,401.96	-
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	149,274,000.00	-
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	25,529,151,800.35	29,567,879,448.63
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		-
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	17,876,432,157.70	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(37,931,522,657.01)	(28,854,670,357.49)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	313,385,640,996.32	265,430,635,263.72
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	313,385,640,996.32	265,430,635,263.72
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	5,982,511.54	-
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	5,982,511.54	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	313,379,658,484.78	265,430,635,263.72
4	Валютын ханшийн зөрүү	(2,958.64)	(51,640,243.48)
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	13,652,071,278.13	9,363,191,777.50
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,162,163,569.30	14,814,234,847.44
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	14,814,234,847.44	24,177,426,624.94

2.5 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2023 төлөвлөгөө	2023 он гүйцэтгэл	Гүйцэтгэл хувь
ХӨДӨЛМӨРИЙН ҮЗҮҮЛЭЛТ				
Нийт ажилчдын тоо /дундаж/	хүн	2,342	2,221	92.6
Цалингийн сан	сая.төг	89,959.6	87,639.5	97.4
Дундаж цалин	сая.төг/сар	3.2	3.20	100.0
ҮЙЛДВЭРЛЭСЭН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТОО		541.09	504.6	93.3
Баруун үйлдвэр	мян.тн	122.2	206.4	168.9
Зүүн үйлдвэр	мян.тн	280.2	145.5	51.9
Төвийн үйлдвэр	мян.тн	138.7	152.8	110.1
ҮЙЛДВЭРЛЭСЭН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨРТӨГ	мян.төг/тн	472.2	504.2	106.8
Баруун үйлдвэр	мян.төг/тн	558.0	540.6	96.9
Зүүн үйлдвэр	мян.төг/тн	465.2	546.1	117.4
Төвийн үйлдвэр	мян.төг/тн	415.9	417.2	100.3
БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТОО	мян.тн	529.1	518.8	98.0
БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНЭ	мян.төг	150.0	150.0	100.0
Борлуулалтын орлого	сая.төг	79,363.3	77,817.9	98.0
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	сая.төг	241,404.8	247,310.8	102.4
Нийт ашиг, алдагдал	сая.төг	(162,041.5)	(169,492.8)	104.6
Бусад орлого	сая.төг		3,983.0	
Удирдлагын зардал	сая.төг	56,473.7	37,925.5	67.2
Борлуулалт, маркетингийн зардал	сая.төг	14,593.6	13,462.1	92.2
Үйл ажиллагааны бус ашиг (алдагдал)	сая.төг	-		
Татварын өмнөх ашиг	сая.төг	(233,108.9)	(217,966.6)	93.5
Татварын зардал	сая.төг	-	71.32	
Цэвэр ашиг	сая.төг	(233,108.9)	(218,037.9)	93.5
Зээлийн санхүүжилтийн орлого	сая.төг	339,930.6	265,430.6	78,1

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 1,143.9 сая төгрөгийн 3 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан.

Залруулсан алдаа:

- Урсгал засварт зарцуулсан 753.4 сая төгрөгийн сэлбэг материал, техник хэрэгслийг үндсэн хөрөнгийн өртөгт капиталжуулаагүй дуусаагүй үйлдвэрлэл дансанд бүртгэснийг залруулж бүртгүүлсэн.
- Зардалд шууд бүртгэсэн 5 нэр төрлийн 249.0 сая төгрөгийн биет бус хөрөнгийг залруулж, биет бус хөрөнгийн дансанд бүртгэсэн.
- Мэргэжлийн хяналтын дүгнэлтээр 2022 онд галд шатсан нь тогтоогдсон ашиглах боломжгүй байгаа тоног төхөөрөмжид тайлант онд 141.5 сая төгрөгийн элэгдлийн зардал тооцсоныг залруулга хийлгэсэн.

Аудитаар 68,789.5 сая төгрөгийн 13 зөрчил¹ илэрснээс, 68,508.2 сая төгрөгийн зөрчилд 9 албан шаардлага хүргүүлж, 281.3 сая төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн 68,789.5 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан байгаа тул “Хязгаарлалттай” санал дүгнэлт өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Урсгал засварт зарцуулсан сэлбэг материал, техник хэрэгслийг үндсэн хөрөнгийн өртөгт капиталжуулж бүртгээгүй, дуусаагүй үйлдвэрлэл дансанд бүртгэсэн	1	753,365.9			1	753,365.9	1	753,365.9				
2	5 нэр төрлийн биет бус хөрөнгийг зардалд бүртгэсэн	1	249,000.0			1	249,000.0	1	249,000.0				
3	2022 онд галд шатсан нь тогтоогдсон ашиглах боломжгүй байгаа тоног төхөөрөмжид 2023 онд элэгдлийн зардал тооцож үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өртөг дансанд бүртгэсэн	1	141,483.1			1	141,483.1	1	141,483.1				
	Дүн	3	1,143,849.1			3	1,143,849.1	3	1,143,849.1				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
1	2020 онд Баруун үйлдвэрийн 1-3 дугаар цехийн дамжуулах шугамыг битүүмжлэх ажилд зарцуулсан хөрөнгийг Дуусаагүй барилга болон өр төлбөр дансанд бүртгэсэн боловч ажлыг хүлээж авсан акт байхгүй, уг битүүмжийн ажил нь бүрэн хийгдснийг нотлох баримт хангалтгүй, , удирдлагын аман шийдвэрээр нураасан гэж тайлбар өгч байгаа ба галд шатсан хөрөнгийг эцэслэн шийдвэрлээгүй	1	966,434.5			1	966,434.5						
2	Өмнөговь аймгийн засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээний хүрээнд Өмнөговь аймгийн сумдад өвс хүргэх 65,000,000 төгрөгийн зардлыг байгууллагын хөрөнгөнөөс гаргаж, зардлыг дуусаагүй үйлдвэрлэлийн дансанд бүртгэсэн	1	65,000.0			1	65,000.0						
3	2023 онд Гүйцэтгэх захирлын А/284, А/366, А/383 тоот тушаалаар батлагдсан галын бодит хохирлыг тогтоох ажлын хэсгийн дүгнэлтээр компанийн хөрөнгөнд бүртгэлтэй хөрөнгө галд шатсаны улмаас	1	1,413,910.6			1	1,413,910.6						

	цаашид ашиглах боломжгүй гэсэн дүгнэлт гаргасан бөгөөд асуудлыг эцэслэн шийдвэрлээгүй байна.												
4	<p>•Засгийн газрын 2021 оны 316 дугаар тогтоол, Эрдэнэс таван толгой ХК, Таван толгой түлш ХХК-иудын ТУЗ-ийн шийдвэрээр Баяжуулах үйлдвэр барих төслийн хүрээнд Иннер Монголиа Күнью Интерпрайс ХХК, Паст Презент Фючэ ХХК-уудтай үйлдвэрийн тоног төхөөрөмж нийлүүлэх, зураг төсөл боловсруулах, техникийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ;</p> <p>•Хагас коксын үйлдвэр барих төслийн хүрээнд THRU LLC, Zheijaing hauding water conservancy engineering Co.,ltd компаниудтай Төслийн ТЭЗҮ, зураг төслийг боловсруулах, төслийг удирдах, шинээр лаборатори байгуулах гэрээнүүдийг сонгон шалгаруулалтгүй шууд байгуулан ажил эхлээгүй байхад дээрх төслүүдийн хүрээнд урьдчилгаа олгосон боловч гэрээт ажил бүрэн хийгдээгүй зогссон байна.</p>	1	14,544,283.3			1	14,544,283.3						
5	Нүүрс баяжуулах болон хагас коксын үйлдвэрийг байгуулах төслийн хүрээнд санхүүжигдсэн 11 гэрээт ажил нь 60-100 хувийн гүйцэтгэлтэй гэж байгаа боловч ажлыг бүрэн хүлээж аваагүй, хөрөнгийн бүртгэлд тусгаагүй, цаашид төслийг үргэлжүүлэх эсэх талаар ТУЗ, хувьцаа эзэмшигчдийн албан ёсны шийдвэр гараагүй төслийн ажлыг зогсоосон.	1	49,836,918.8			1	49,836,918.8						

6	Ажилтнуудын илүү цагийн хөлсийг бодит ажилласан цагтай уялдуулалгүй илүү тооцож олгосон.	1	284,344.7			1	284,344.7						
7	ТУЗ-ийн дэргэдэх Дотоод Аудитын газар, Гүйцэтгэх захирлын дэргэдэх Дотоод хяналтын хэлтсүүдийн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт хангалтгүй	1	-			1	-						
8	Үйлдвэрийн түүхий эд барьцалдуулагчийг худалдан авах, мидлинг тээвэрлэх, вагонд ачихад бэлтгэхэд зориулж тээврийн хэрэгсэл түрээслэх ажлуудыг шууд гэрээ хийж гүйцэтгүүлсэн Нэг ижил төрлийн ажлын төсөвт өртгийг хувааж 3 аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн.	1	1,397,299.4			1	1,397,299.4						
9	Таван толгой түлш ХХК нь 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан болон бусад аудитад шаардлагатай нягтлан бодох бүртгэлийн журнал, мэдээ тайлангуудыг хуулиар тогтоосон болон аудиторын шаардсан хугацаанд бэлтгэж ирүүлээгүй.	1	-			1	-						
10	Нэг төрлийн үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг өөр өөрөөр тогтоож элэгдлийг тооцдог, НББББ-д үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг хөрөнгө бүрийн хувьд шинээр тогтоох тухай Гүйцэтгэх	1	-					1	-				

	захирлын тушаал гарсан нь хэрэгжээгүй,												
11	Бараа ажил үйлчилгээ худалдан авах гэрээний биелэлтэд Чанарын хяналтын болон Захиалагчийн хяналтын хэлтсээс тавих хяналт сул, хяналтын актын цахим сан бүрэн бус байна.	1	-					1	-				
12	Сайжруулсан шахмал түлшний борлуулалтын үйл ажиллагааны аудитын хүрээнд үйлдвэр болон агуулахад байгаа шахмал түлшний хөдөлгөөн, жилийн эцсийн үлдэгдлийн дүнг Борлуулалтын болон санхүүгийн программаас гарч байгаа журнал болон нягтлан бодогч нарын тайлантай тулгаж үзэхэд нягтлан бодогч нарын хөтөлсөн бүртгэл нь 1.4 сая төгрөгөөр алдаатай илэрхийлэгдсэн байна.	1	1,434.7					1	1,434.7				
13	Анхан шатны Е-баримтгүй гүйлгээг хийсэн.	1	279,910.5					1	279,910.5				
	Дүн	13	68,789,536.5				9	68,508,191.3	4	281,345.2			

Аудитаар нийт 68,789.5 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 68,508.2 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 281.3 сая төгрөгийн зөвлөмж өгсөн.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
				Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	<i>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</i>						
	шилэн дансны цахим хуудсанд нийт 26 төрлийн 169 мэдээг ил тод байршуулахаас төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төсвийн төлөвлөгөөний гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, хөрөнгийн зардал, санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт гэсэн 5 төрлийн 7 мэдээг хугацаа хоцроож байршуулсан	1	-	1	-		
2	Нийт дүн	1	-	1	-		

АДБООС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 1 зөрчил илэрснээс 1 албан шаардлага хүргүүлсэн.